

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021-04-29

Мөрөн

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын зааланд 2021 оны 04-р сарын 29-ны өдрийн 14.00 цагт эхлэв.

Хурлын ирцийг “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн ТУЗ-ийн Хурлын дарга Л.Дашицэрэн ирцийг 83.2 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв

Хурлын дарга Л.Дашицэрэн- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

Гүйцэтгэх захирал Л.Төмөрбаатар- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

- Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэв.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр - Хянан шалгах зөвлөлийн тайлан

Хурлын дарга Л.Дашицэрэн - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв зэрэг асуудлыг хэлэлцүүлж санал хураалт явуулав.

2020 оны жилийн эцэст ашиггүй ажилласан тул ногдол ашиг хувиарлах боломжгүй болсон.

За дээрхи асуудлуудтай холбоотой санал хүсэлт байна уу?

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл- Тооллогын комиссын дүнг танилцуулав.

Хурлын дарга Л.Дашицэрэн- Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал- Л.Төмөрбаатар - 2021 онд компаний хэмжээнд дараах ажлуудыг бизнес төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж ажиллаж байна.

1. Үйлдвэрлэлийн чанарын хяналтыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог нарийн зохион байгуулалтад оруулж, тусгай журманд оруулах.

2. Талх нарийн боов, архи, цэвэр ус, жимсний цехүүдийн үйлдвэрлэлийн байр барилга байшинг орчин үеийн эрүүл ахуйн стандартын түвшинд хүргэх.
3. Талхны үйлдвэрлэлийн орчин үеийн шинэ шугамыг ашиглалтад оруулах, үйлдвэрлэлийн хэмжээнд тоног төхөөрөмжийн иж бүрэн шинэчлэлийг хийх.
4. Бүтээгдэхүүний сав баглаа боодлыг шинэчлэх сайжруулах шинэ өнгө төрхийг бий болгож, багцын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.
5. Талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт хийх /орц жорын сонголт /норм, түүхий эд материалын, бүтээгдэхүүний чанарын сайжруулалтыг иж бүрнээр хэрэгжүүлнэ.
6. Архины шүүлтийг бүрэн шинэчилж евро стандартын шүүлтүүрийг үйлдвэрлэлтэд нэвтрүүлэх.
7. Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх /мах нөөшлөх, ногоо нөөшлөх, хатаах, савлах, утах/ гэх мэт.
8. Сүү цагаан идээ, байгальн баялаг ашиглах экологийн цэвэр хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн технологийн арга ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авна.
9. Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах бүх талын арга хэмжээг шат дараатай зохион байгуулах
10. Талх нарийн боовны цехийн үйлдвэрлэл борлуулалтыг Хөвсгөл аймгийн зах зээлд шинэ шатанд гаргах
11. Хөвсгөл далайн цэвэр усыг үйлдвэрийн аргаар боловсруулж монгол улсын зах зээлд нэвтрүүлэх.
12. Компанийн гол нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг Монгол улсын зах зээлд гаргах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 15.10 минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТУЗ-ИЙН ДАРГА  Л.ДАШЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  С.ОТГОНБААТАР

